



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 1д сарын 23 өдөр

Дугаар А/830

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1 дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хөдөлмөр халамжийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх үйлсэд хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн судалгаа, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхзул, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Дүйсенбек нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан албан хаагчдад 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Л.Билэгдэмбэрэл)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

Zah A/830 Am  
8400 01 3363